



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/203

Мөрөн сум

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох (1) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбицол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Бүрэнтогтох сумын Засаг дарга (А.Аззаяа) нарт тус тус даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

4.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.


5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 16-ний өдрийн А/...
дугаар захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛБАЙ, СОЛБИЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сум, талбайн нэр	Талбай н хэмжээ га	Хугацаа		Солбицол	
				Эхлэх	Дуусах	Уртлаг	Өргөрөг
1	Эрдэм- Үүд ХХК	Бүрэнтогтох сум Туяа баг	25,2	2022 оны 06 сарын 16	2025 оны 06 сарын 16	100 00 04.43 100 00 38.99 100 00 39.17 100 00 04.41	49 38 17.4 49 38 17.46 49 38 29.09 49 38 29.31

_____ ооо _____